

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар A/10.

Арвайхээр сум

Г

Эрүүл мэндийн газрын биеийн тамир,  
спортын хамтлагийн ажиллах журам,  
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Биеийн тамир, спортын хамтлагийн дүрэм шинэчлэн батлах тухай" А/469 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэдэх "Биеийн тамир, спортын хамтлаг"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хамтлагийн ахлагч (С.Цэнддүлам)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Биеийн тамир, спортын хамтлагийг шинэчлэн байгуулах тухай" А/37 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



622301000

Эрүүл мэндийн газрын даргын 2024  
оны 10 дугаар сарын 28-ны өдрийн  
10.дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БИЕЙН ТАМИР,  
СПОРТЫН ХАМТЛАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:

С.Цэнддулам, Халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Ю.Ичинноров, Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга

М.Мөнхбаатар, Эдийн засагч

Ж.Очирсурэн, Халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн

П.Оюунбилэг, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа, ёс зүй, шагнал  
хариуцсан мэргэжилтэн



**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ХАМТЛАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл:**

- 1.1 Биеийн тамир, спортын хамтлаг нь (цаашид хамтлаг гэх) тухайн аж ахуйн нэгж, байгууллагад биеийн тамир, спортын арга хэмжээний талаар үйл ажиллагаа төлөвлөгөөг боловсруулан, шийдвэрийг хэрэгжүүлэх биеийн тамир, спортын нэгж мөн.
- 1.2 Хамтлагийн үндсэн зорилго: Албан хаагчдын бие, бялдрыг чийрэгжүүлэх, оюун санаа, эрүүл мэндийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх, төлөвшүүлэх үндсэн дээр байгууллагын хүний хөгжлийг дээшлүүлэн хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд оршино.

**Хоёр. Бүтэц, удирдлага зохион байгуулалт**

- 2.1 Биеийн тамир, спортын хамтлаг нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2 Хамтлаг нь хамт олны хурлаас хамтлагийн ахлагч, гишүүдийг сонгож, байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан багийн зохион байгуулалтаар ажиллана.
- 2.3 Хамтлаг нь биеийн тамир, спортын бүх төрлөөр төлөвлөгөөт үйл ажиллагааг идэхжүүлэн, тухай бүрт нь хуралдаж гишүүдийн чиг үүргийг тодорхойлон ажиллас чиг үүрэгтэй.

**Гурав. Биеийн тамир, спортын хамтлагийн эрх үүрэг**

**3.1 Хамтлаг нь дараах эрх эдэлнэ:**

- 3.1.1 Тухайн жилд хамт олны дунд зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, зохих шийдвэрийг гаргуулах, сурталчлах.
- 3.1.2 Биеийн тамир, спортын уралдаан тэмцээний заавар, журам, арга зүйн удирдамж зэргийг гарган зохион байгуулах.
- 3.1.3. Улсын чанартай болон аймгийн томоохон уралдаан тэмцээнд бэлтгэж байгаа үед ажлын 5 хоногийн өдрүүдэд 1-2 цагийн чөлөө олгох асуудлыг удирдлагад тавьж шийдвэрлүүлэх.
- 3.1.4 Аймаг орон нутаг, салбарын тэмцээн, байгууллагын спортын үйл ажиллагаанд амжилттай оролцсон албан хаагчид ажлын 1 өдрийн амралт олгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх
- 3.1.5 Эрүүл мэндийн газрын хамт олны дундын мөнгөн хуримтлалын сангаас тус

сангийн журмын 3.1.7 дугаар заалтын дагуу аливаа биеийн тамирын уралдаан тэмцээнд мөнгөн дэмжлэг авч зарцуулах

3.1.6 Улсын болон аймаг орон нутаг, салбарын тэмцээн уралдаанд оролцож мөнгөн шагналаар шагнагдсан үед дараах төрлөөр журамлаж спорт хамтлагийн мөнгөн хуримтлалын санг бүрдүүлэн, хамтлагийн үйл ажиллагаанд зарцуулах

- Байгууллага, хамт олноор шагнал авбал 20 хувь
- Багийн төрөлд 15 хувь
- Ганцаарчилсан төрөлд 10 хувь

### **3.2 Хамтлаг нь дараах үүрэг хүлээнэ:**

3.2.1 Хамт олны дунд явуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг байгууллагынхаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна.

3.2.2 Хамтлагийн гишүүд нь аливаа биеийн тамир, спортын үйл ажиллагааг хамтын шийдвэрээр зохион байгуулж, удирдлага, хамт олондоо тайлagnana.

3.2.3 Тухайн жилд хамт олны дунд зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, зохих шийдвэрийн гаргуулах, сурталчлах.

3.2.4 Спортын уралдаан тэмцээн болон биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлын арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг нь тооцох.

3.2.5 Байгууллага хамт олныг 7 хоногт 1 удаа спорт зааланд тоглуулах ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагатай гэрээ хийж, хэрэгжүүлэх.

3.2.6 Албан хаагчдын биеийн тамир, спортоор хичээллэх болон бие бялдрын түвшин тогтоох сорил авах, эрүүл мэндийн хяналт тавих нөхөн сэргээх зэрэг ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх.

3.2.7 Аймаг орон нутаг, салбарын спортын арга хэмжээг зохион байгуулах болон оролцох тухай хамтлагаар хэлэлцэж удирдлагын багаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх.

### **Дөрөв. Бусад**

4.1 Хамтлаг тайлангаа тухайн оны 12 дугаар сарын 25-ны дотор удирдлага, хамт олондоо тайлagnаж үр дүнг тооцно.